

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ.
“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ДАШДАВАА

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ.
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.МӨНХӨӨ

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

2023.10.12

№

2023/88

Улаанбаатар хот

Нэг талаас “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК /цаашид гүйцэтгэгч гэх/-ийг төлөөлж Захиргаа удирдлагын хэлтсийн Сургалт, бүтээмжийн инженер Л. Энхжаргал, нөгөө талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М. Мөнхөө нар Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2003 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийг хэрэгжүүлэх зорилгоор дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн шуурхай ажиллагааны ажилтнуудад цахилгааны аюулгүй ажиллагааны группийн эрх олгох сургалтыг өөрийн мэргэжлийн ур чадвартай инженер, техникийн ажилтнуудаар зохион байгуулах, захиалагч нь энэхүү сургалт зохион байгуулахтай холбогдон гарсан төлбөр төлөх зэрэг талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгч нь сургалтыг энэхүү гэрээний хавсралт №1-д заасан хөтөлбөрийн дагуу, хавсралт №2-д заасан захиалагчийн ажилтнуудад цахим хэлбэрээр зохион байгуулна.

Хоёр. Гэрээний үнэ

- 2.1 Захиалагч нь сургалтын төлбөр болох 3,189,120 (Гурван сая нэг зуун наян есөн мянга нэг зуун хорь)-н төгрөгийг гүйцэтгэгчийн Төрийн банк дахь 346 900 248 559 /ЦДҮСҮЛЖЭЭ/ дансанд сургалт эхлэхээс 3 хоногийн өмнө шилжүүлсэн байна. Үнийн дүнд НӨАТ орсон болно.
- 2.2 Сургалтын төлбөрийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам”-ыг үндэслэн гаргасан “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/212 дугаар тушаалын хавсралтад тусгасны дагуу тооцсон болно.

Гурав. Хугацаа

- 3.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл нийт 30 хоногийн хугацаанд хүчинтэй бөгөөд талууд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд гэрээ дүгнэсэн акт үйлдэж, гэрээг дуусгавар болсонд тооцно.

Дөрөв. Талуудын хүлээх үүрэг.

- 4.1 Захиалагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг:

- 4.1.1 Сургалтад хамрагдах ажилтнуудын нэрсийн жагсаалтыг гүйцэтгэгч талд гаргаж өгнө.
- 4.1.2 Суралцагсдын сургалтын хугацаанд идэвхи зүтгэлтэй суралцах, хичээлээс хоцрох, таслах явдлыг гаргахгүй байх тал дээр анхаарна.
- 4.1.3 Суралцагсад нь цахилгааны мэргэжлээр их дээд сургуулийг төгссөн, ажлын байрны шаардлагыг хангасан зохих дадлага туршлагатай байна.
- 4.1.4 Суралцагсдын шуурхай ажиллагааг найдвартай зохион байгуулж, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг захиалагч тал хариуцна.
- 4.1.5 Захилагч нь аюулгүй ажиллагаа хариуцагч нарын тушаалыг өөрийн байгууллага дээр гаргаж, хэрэгжүүлнэ.
- 4.1.6 Сургалт эхэлснээс хойш хавсралт №2-д заасан суралцагсдыг солихгүй.

- 4.2 Гүйцэтгэгчийн эдлэх эрх, хүлээх үүрэг:

- 4.2.1 Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай явуулна.
- 4.2.2 Гүйцэтгэгч нь сургалттай холбоотой ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба сургалтын батламж, мэргэшлийн үнэмлэх олгохгүй.
- 4.2.3 Цахилгааны аюулгүй ажиллагааны группийн үнэмлэхийг шалгалтад тэнцэж, шаардлага хангасан ажилтнуудад олгоно.
- 4.2.4 Гэрээний төлбөрийг хугацаандаа гаргуулан авах эрхтэй.

Тав. Гэрээ цуцлах

- 5.1 Дараах тохиолдолд талууд гэрээг цуцална.

- 5.1.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгээгүй.
- 5.1.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр тохиролцсоны дагуу ажлаа гүйцэтгэсэн боловч захиалагч гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол гүйцэтгэгчийн санаачлагаар цуцална.

- 5.2 Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас гэрээг цуцалсан тохиолдолд учирсан шууд болон шууд бус аливаа хохирлыг буруутай талаар нөхөн төлүүлнэ.

Зургаа. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал

- 6.1 Талуудын аль нэг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

- 6.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжээгүй тохиолдолд гэрээний аль нэг тал нөгөө талаасаа алданги, торгууль зэрэг аливаа хохирлыг нөхөн төлөхийг шаардахгүй.
- 6.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнийг зөвхөн эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн тогтооно.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1 Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэнэ.
- 7.2 Гэрээнд тусгаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Найм. Бусад нөхцөл

- 8.1 Энэхүү гэрээг монгол хэл дээр тус бүр 3 хувь үйлдэн, Захиалагч 1, Гүйцэтгэгч 2 хувийг тус тус хадгална.
- 8.2 Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.3 Талууд энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд нэмэлт өөрчлөлтийн гэрээ бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.4 Захиалагч талаас албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд Хавсралт №2-д заасан суралцагчийг өөрчилж болох ба сургалт эхэлснээс ажлын 1 хоногийн дараа суралцагчийг солих боломжгүй.
- 8.5 Сургалтыг зөвхөн сургалт эхлэхээс өмнө хойшлуулах боломжтой бөгөөд сургалт эхэлсэн тохиолдолд хойшлуулах боломжгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер



Б.Эрхэмзаяа

Ерөнхий нягтлан бодогч




Э.Болор-Эрдэнэ

ЗУХ-ийн гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

Н.Үүрцайх

ЗУХ-ийн сургалт, бүтээмжийн инженер



Л.Энхжаргал


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Амгалан дулааны станц ТӨХК-ийн
Ерөнхий инженер



Э.Мөнхжаргал

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга



Б.Ган-Очир

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
бөгөөд Ерөнхий нягтлан бодогч:



Ө.Удвал

Хуулийн мэргэжилтэн:



Г.Саруул

Хаяг: "Цахилгаан Дамжуулах Үндэсний
Сүлжээ" ТӨХК, Хан-Уул дүүрэг, 3
дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45

Утас: 70042939, 99191300,
Факс: 70043287

Сургалт, судалгааны мэргэжилтэн

Н.Пагмаа



Хаяг: "Амгалан дулааны станц" ТӨХК,
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р
хороо Ус-15-1-1,

Утас: 77111250